

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар A/15.

Арвайхээр сум

Өндөр тунт А аминдэм орлогод авах,
хуваарилах тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Заавар батлах тухай” А/490 дүгээр тушаал, 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Өндөр тунт А аминдэм орлогод авах, хуваарилах тухай” А/171 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сангаар дамжуулан хуваарилагдсан 6,111,773.6 (зургаан сая нэг зуун арван нэг мянга долоон зуун далан гурав) төгрөгийн үнийн дүн бүхий 6-59 сартай хүүхдэд уулгах өндөр тунт А аминдэмийг Эрүүл мэндийн газрын орлогод авах жагсаалтыг нэгдүгээр, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарилах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өндөр тунт А аминдэмийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг нягтлан бодогч (Б.Валя)-д даалгасугай.

3. Хуваарийн дагуу өндөр тунт А аминдэмийг харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 5 хүртэлх насны хүүхдэд халдвар хамгааллын дэглэмийг сахин түгээж, тайланг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст ирүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

4. Өндөр тунт А аминдэмийн ач холбогдол, хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулан, мэргэжил арга зүйгээр хангаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н. ОЮУНТУЯА



622091082

D:My.Doc.Tushaal. EMG

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн 44 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ӨНДӨР ТУНТ А АМИНДЭМИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ОРЛОГОД АВАХ ЖАГСААЛТ

№	Нэр, төрөл	Гарал үүсэл	Үйлдвэрлэгч	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж үнэ (төгрөг)	Нийт дүн (төгрөг)
1.	Өндөр тунт А Аминдэм (100,000 ОУН)	Данийн Хаант Улс	НутриКорп Интернационал компани	1000	151.94	151,940
2.	Өндөр тунт А Аминдэм (200,000 ОУН)	Данийн Хаант Улс	НутриКорп Интернационал компани	38640	154.24	5,959,833.6
Нийт үнэ						6,111,773.6

Жич:

1.Валютын ханшийн тооцоолол:

Гааль, татварын нэгдсэн системд бүртгэгдсэн огноог үндэслэн Монгол банкны тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн тооцоолсон. Үүнд:

- Өндөр тунт А аминдэм (100,000 ОУН)-ий хувьд 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн ханш 1 ам.доллар=3,556.93 төгрөг,
- Өндөр тунт А аминдэм (200,000 ОУН)-ий хувьд 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн ханш 1 ам.доллар=3,570.71 төгрөг.

2.Зардлын тооцоолол:

Дээрх бүтээгдэхүүний өртгийг тооцоолохдоо худалдан авах үнэ, тээвэрлэлтийн зардал, гаалийн болон бусад холбогдох зардлуудыг нэгтгэн тооцож, ам.долларын дүнг тухайн бараа хилээр орж ирсэн өдрийн Монгол банкны ханшаар хөрвүүлэн, нэгж үнэ болон нийт үнийн дүнг тус тус тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн 4/ дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ӨНДӨР ТУНТ А АМИНДЭМ ХУВААРИЛАХ ЖАГСААЛТ

№	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	6-11 сартай хүүхэд			12-59 сартай хүүхэд		
		Хүүхдийн тоо	100.000 ОУН	Үнэ/төгрөг (1ш*151.94)	Хүүхдийн н тоо	200.000 ОУН	Үнэ/төгрөг (1ш*154.24)
1.	Баруун баян-Улаан	50	20	3038.8	179	1000	154240
2.	Бат-Өлзий	120	100	15194	521	2500	385600
3.	Баянгол	20	20	3038.8	222	1000	154240
4.	Баян-Өндөр	50	30	4558.2	213	1000	154240
5.	Богд	40	40	6077.6	413	2500	385600
6.	Бүрд	35	20	3038.8	176	1000	154240
7.	Гучин-Ус	35	20	3038.8	132	1000	154240
8.	Есөнзүйл	20	20	3038.8	155	1000	154240
9.	Зүүнбаян- Улаан	30	20	3038.8	212	1000	154240
10.	Нарийнтээл	30	20	3038.8	199	1000	154240
11.	Өлзийт	35	20	3038.8	118	1000	154240
12.	Сант	20	20	3038.8	208	1000	154240
13.	Тарагт	20	20	3038.8	212	1000	154240
14.	Төгрөг	25	20	3038.8	145	1000	154240
15.	Уянга	70	70	10635.8	672	2500	385600
16.	Хайрхан дулаан	20	20	3038.8	200	1000	154240
17.	Хужирт	60	50	7597	419	2500	385600
18.	Уянсэтгэл ӨЭМТ	180	150	22791	773	3500	539840
19.	Түшиг дөлгөөн ӨЭМТ	70	70	10635.8	761	3500	539840
20.	Нарны дөш ӨЭМТ	190	150	22791	1581	4500	694080
21.	Энэрэл-ХХ ӨЭМТ	100	100	15194	878	3500	539840
Нийт		1220	1000	151940	8389	38000	5.861.120

Тайлбар: 06-11 сартай хүүхдэд 200000 ОУН тунтай А аминдэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/490 дүгээр тушаалыг дагуу 1/2 капсул (3 дусал)-ыг 100.000 ОУН -ээр тооцон уулгана.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/490 дүгээр тушаалын дагуу 6-11 сартай хүүхдэд жилд 1 удаа, 12-59 сартай хүүхдэд жилд 2 удаа /05, 11 саруудад/ уулгах заалттай байдаг. Иймд захиалгыг 2 удаа олгохоор тооцож олгосон болно. Мөн урьдчилсан захиалгыг хүүхдийн тоог 5 хувиар нэмэгдүүлж тооцож захиалсан болно.